БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН 221
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

# Зарлиг

1959 он 8 дугаар сарын 14 өдөр. дугаар 133

Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТОД ХОРОО ЗАХИРГАА БАЙГУУЛАХ ТУХАЙ

Б Н М А Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс Т О Г Т О О Х нь:

Нэг. Найрамдалын хорооноос 10,11,12,13,14,15,16-р хорин, Чингэлтийн хорооноос 9,10-р хорин, Сүхбаатарын хорооноос 5-р хорин, Чойбалсангийн хорооноос 9-р хорин, эдгээр хорьдыг дээрхи хороодоос хасч бүгд 11 хориныг шилжүүлэн Зүүн-Сэлбийн хороог шинээр байгуулсугай.

Хоёр. Хоршооллын хорооны 9-р хорин, Чойбалсангийн хорооны 8-р хориныг Төмөр-замын хороонд шилжүүлэн Төмөр-замын хороог 8 хоринтой болгосугай.

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Самбуу (Ж. САМБУУ)

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга (Д. БАЛЖИННЯМ)

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /М. ХАШГАМБАЙ/

/Ц. ДАМДИНСҮРЭН /

Тэргүүлэгчид: (С. ЯНЖМАА)
(М. ХАШГАМБАЙ)
(Д. ТӨМӨР-ОЧИР)

983

# Б. Н. М. А. У.

# Сайд нарын Зөвлөл

195 9 он 8 сарын 13 өдөр. Улаанбаатар хот.

Дугаар 63.

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн
газрын дарга Самбуу Танаа

Улаанбаатар хотын зарим хороодын хүн ам өрх аж ахуй олширч өргөжсөнөөс хороо захиргааны үйлчлэх хүрээ хэтэрхий их болж, хөдөлмөрчдөд хүрэлцэн үйлчлэхэд бололцоогүй байгааг харгалзан Найрамдлын хорооноос 10,11,12,13,14, 15,16-р хорин, Чингэлтэйн хорооноос 9,10-р хорин, Сүхбаатарын хорооны 9-р хорин, Чойбалсангийн хорооноос 9-р хорин бүгд 11 хоринг дээрхи хороодоос хасч шилжүүлэн „Зүүн сэлбийн хороо" захиргаа нэмэн байгуулах ба Хоршоллын хорооны 9-р хорин, Чойбалсангийн хорооны 8-р хориныг Төмөр замын хороонд шилжүүлэн мөн хороог 8 хоринтой болгохыг зөвшөөрч зарлиг гаргаж өгөхийг Танаас хүсье.

САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН
ОРЛОГЧ ДАРГА /МОЛОМЖАМЦ/